



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 30 өдөр

Дугаар A/118

Алтанбулаг

Г Хөдөлгөөн хязгаарлах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Коронавируст халдварт /ковид-19-/ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7¹.1, Сумын онцгой комиссын 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 6 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд гэрийн ажиглалтанд байсан иргэнээс коронавируст халдварт ковид-19-ын 1 тохиолдол батлагдсантай холбогдуулан 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 08:00 цагаас 2021 оны 05 дугаар сарын 31-ны 00:00 цаг хүртэл сумын орох, гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарласугай.
2. Тандалт судалгааны ажил хийгдэж байгаа тул иргэд Хүнсний дэлгүүр, ус түгээгүүрийн газар, эмийн сан орохоос бусад тохиолдолд гэрээсээ гарахгүй байхыг анхааруулж хяналт тавьж ажиллахыг 1,2 дугаар багийн Засаг дарга /Б.Баттулга/-д даалгасугай.
3. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгж, нийтийн эзэмшилийн талбайд ариутгал халдвартгүйжүүлэлт хийлгэх ажил зохион байгууллахыг Хүнс жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Одмаа/, 1,2 дугаар багийн Засаг дарга /Б.Баттулга/ нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг шуурхай штабын дарга /Ү.Янжиндулам/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ОТГОНЦОГТ

